

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

1997 оны 03 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Үйлчилгээний хураамжийн талаар
санал болгох тухай

Монголын хөрөнгийн биржээс ирүүлсэн санал, үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 7дахь заалтыг үндэслэн Монгол улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ НЬ:

~~1. Үнэт цаасны гүйлгээний дүнгээс авах үйлчилгээний хураамжийн дээд хязгаарыг орон нутгийн байршилтай үнэт цаасны компани, салбарт 9 хувиас, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотод байршилтай үнэт цаасны компани, салбарт 5 хувиас хэтрэхгүй байхаар тогтоож мөрдөхийг үнэт цаасны компаниудын удирдлагад санал болгосугай.~~

/Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 19 дүгээр тогтоолоор хүчингүй/

2. Компани тус бүр сарын орлого дарлагын тооцоог нарийвчлан гаргаж санал болгоёон хураамжийн дээд хэмжээнд үйл ажиллагаа явуулахад зардлаа нөхөж чадахааргүй бол Хороонд асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэхийг үнэт цаасны компани удирдлагуудад үүрэг болгосугай.

3. хураамжийн хэмжээг 1997 оны 4 дүгээр сарын 1-ний дотор үнэт цаасны компани тус бүрийн удирдлагын шийдвэрээр тогтоож мөрдөхийг бүх компанийн удирдлагуудад даалгасугай.

4. Үнэт цаасны компани тус бүрийн гүйлгээний дүнгээс авах үйлчилгээний хураамжаас Монголын хөрөнгийн биржид үлдэх хэмжээг гүйлгээний дүнгийн 1 хувиас хэтрэхгүй байхаар тогтоосугай.

5. Монголын хөрөнгийн биржээс хороонд оруулсан хөрөнгийн хураамжийн хэмжээг хянаж үзээд биржийн удирдлагад дараах асуудлыг санал болгосугай.

1/ ХОЭБ – ээр хувьцаа авсан этгээд биржийн төвлөрсөн хадгаламжид данс нээлгэхэд 150 төгрөг хүртэл , харилцагчийн холболтын данс нээлгэхэд 1000 төгрөг хүртэл, нас барсан харилцагчийн үнэт аас өмчлөх эрхийг нотриатаас баталгаажуулсан нэр бүхий иргэнд шилжүүлэхэд хүлээн авч буй харилцагчаас тухайн үнэт цаасны хаалтийн ханшаар тооцсон үнийн дүнгээс 3 хүртэл хувийн шимтгэл, данс нээгээгүй боловч, МХБ-ийн клирингийн данс ашиглан гүйлгээ хийж байгаа этгээдээс мөнгөн хөрөнгийн дүнгийн 3 хүртэл хувийн үйлчилгээний хураамж тус тус авч болох .

2/ Харилцагч шинээр данс нээлгэхэд 10000 төгрөг авах , аж ахуйн нэгж болох хуулийн этгээд болон түүний салбар шинээр данс нээлгэхэд 50000 төгрөг авах, харилцагч өмчилж байгаа үнэт цаасаа бусдад бэлэглэх, хандивлах зэргээр үнэ төлбөргүй шилжүүлэхэд харилцагч тус бүрээс тухайн үнэт цаасны хаалтын ханшаар тооцон үнийн дүнгээс харилцагч тус бүрээс _ хувийн шимтгэл авах саналыг тус бүрд бууруулж тогтоох.

3/ Харилцагч арилжааны бус хэлбэрээр өмчилж буй үнэт цаасаа нэр заан бусдад худалдахад тухайн үнэт цаасны хаалтын ханшаар тооцон харилцагчаас тодорхой хувиар авах шимтгэл, тендер саналаар арилжааны бус хэлбэрээр хувьцааны бүртгэлийг шилжүүлэхэд харилцагч тус бүрээс үнийн дүнгийн 2 хувиар авах шимтгэл болон компанийн шинээр бүртгэгдсэн үнэт цаас, компанийн нэмж гаргасан үнэт цаасыг арилжааны бус хэлбэрээр нэр заан өмчлүүлж байгаа тохиолдолд харилцагчаас тодорхой хувиар авах шимтгэлийн хэмжээг үнэт цаасны үнийн дүн өсөх тутам хувийг бууруулах замаар тодорхой шатлалтай тогтоох саналыг боловсруулж Хороонд дахин оруулах.

6. Үнэт цаасыг зуучлан худалдах, арилжихтай холбогдон шинэ нэр төрлийн үнэлгээ бий болгох тохиолдолд авах хураамжийн хэмжээг тогтоох саналыг хороонд тухай бүр оруулж санал авч тогтоон төрдөн ажиллахыг Монголын хөрөнгийн бирж, Үнэт асны компаниудын удиирдлагад үүрэг болгосугай.

7. тогтоолын хэрэгжилт мөрдөж байгаа үйлчилгээний хураамжийн хэмжээнд байнгийн хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/, тонголын хөрөнгийн бирж /О.Энхбаяр/ -д даалгасугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН